

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2018 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан	3
2.1	Оршил	4
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал	8
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.11	Шилэн дансны мэдээлэл	9
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	9
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	9
3	Менежментийн захидал	10
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан	12
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	12-13
4.2	Аудитын хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	14-15
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	16-18
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	19
4.5	Аудит төсвийн гүйцэтгэлийн тайлан	20-21
Хавсралт		

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2019.02.25 № 06/213
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу Зам, тээврийн хөгжлийн яамны 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Зам, тээврийн хөгжлийн яамны 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Зам, тээврийн хөгжлийн яамны 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлсэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.1. Оршил

Зам, тээврийн хөгжлийн яамны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Зам, тээврийн хөгжлийн яамны 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Зам, тээврийн хөгжлийн яамны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 1 дүгээр сарын 25-наас 2019 оны 2 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 2 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Санхүүгийн аудитын газрын аудитор Б.Сэржмядаг, Г.Мөнхчимэг нар хариуцаж хэрэгжүүлэв.

Зам, тээврийн хөгжлийн яам 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Санхүүгийн аудитын газарт 2019 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 03/370 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Зам, тээврийн хөгжлийн яамны талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Зам, тээврийн хөгжлийн яамны эрхэм зорилго нь эдийн засгийн өсөлтийг хангах зам, тээвэр, логистикийн сүлжээг өргөжүүлэн хөгжүүлэх, хэрэглэгчийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, эдийн засгийн үр ашигтай, аюулгүй, ая тухтай тээврийн үйлчилгээний нөхцөлийг бий болгох явдал юм.

Зам, тээврийн хөгжлийн яамны үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Зам, тээврийн хөгжлийн яамны удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Авто замын тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

Зам, тээврийн хөгжлийн яам 2018 онд дараах онцлох ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- Нисэх, төмөр зам, авто тээврийн салбарт Засгийн газар хоорондын нийт 8 хэлэлцээрийг байгуулсан
- Төмөр зам, иргэний нисэхийн салбарын бодлогын баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулж, авто тээврийн салбарын бодлогын баримт бичгийг шинээр батлуулсан
- Дорноговь аймгийн Замын-Үүд суманд Бүс нутгийн логистикийн төв, 3 зам дагуух үйлчилгээний байгууламж, 2 авто буудал барьж ашиглалтад оруулсан
- Олон улс, улсын чанартай нийт 1030.2 км хатуу хучилттай авто замын бүтээн байгуулалтын ажлыг хэрэгжүүлж, нийт 403.8 км хатуу хучилттай авто замын барилгын ажлыг бүрэн дуусгаж, хөдөлгөөн нээсэн байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Зам, тээврийн хөгжлийн яамны санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Зам, тээврийн хөгжлийн яам санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн "Acoulous" програм хангамж ашигладаг байна.

Зам, тээврийн хөгжлийн яамны дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Зам, тээврийн хөгжлийн яамны бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 18 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 5 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг

баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны үр дүнгийн тайлангийн зардлын 1 хувиар сонгов.

Зам, тээврийн хөгжлийн яамны 2018 оны санхүүгийн тайланд аудит хийж санал дүгнэлт гаргахад шаардлагатай материаллаг байдлын түвшинг гүйцэтгэлийн үе шатанд тооцохдоо суурь үзүүлэлтийг 2018 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардал сонгох нь зохимжтой гэж үзэв.

Зам, тээврийн хөгжлийн яамны 2018 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 6,211,389.4 мянган төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 62,113.9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 6 чиглэлээр аудитын 18 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 5 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 13 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 3 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулж 2 асуудалд зөвлөмж хүргүүллээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

№	Шийдэл	Тоо	Дүн	/мянган төгрөгөөр/ Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	2	15,667.4	
	Дүн	2	15,667.4	

2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Зам тээврийн хөгжлийн яамны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар бүртгэл тайлагнал, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой алдаа, аудитын явцад залруулж, 15,667.4 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж хүргүүлээ.

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

1. Төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан маягтаар бэлтгээгүй, хөтөлбөр зориулалт болон төсвийн хэлбэлзлийн тайлан, тохируулгын тайлан гаргаагүй нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйл, Сангийн сайдын 2013 оны 76 дугаар тушаалаар батлагдсан журмыг хэрэгжүүлж ажиллаагүй байгааг аудитын явцад залруулсан
2. Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй тайлан болон элэгдлийн тайлангаас элэгдлийг давтан тооцоолоход сүүлийн хагас жилийн элэгдэл байгуулаагүй байсныг аудитын явцад заруулсан.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Техник хяналтын харилцах дансанд байршуулсан техник хяналт тавих зардалд зарцуулах 4,469,046.3 мянган төгрөг байгаагаас 1,253,288.9 мянган төгрөг нь улсын комисс хүлээн авсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хяналтын зардал байгааг завсрын аудитын явцад улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Зам, тээврийн хөгжлийн яамны дараагийн тайлангийн аудитаар анхаарал хандуулах асуудал байхгүй байна.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Зам, тээврийн хөгжлийн яамны чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 2 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 3,221,282.6 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Зам, тээврийн хөгжлийн яамны урсгал үйл ажиллагааны зардалд 3,221,282.6 мянган төгрөг батлагдаж санхүүжилт авснаас гүйцэтгэлээр 3,192,213.4 мянган төгрөг гарч 99.1 хувийн биелэлттэй байна.

Мөн Засгийн газрын 2018 оны 122 дугаар тогтоолоор Засгийн газрын нөөц сангаас 939.444.0 мянган төгрөгийн микро автобусны төлбөрт, улсын чанартай авто замыг сэргээн засварлахад 1,867,355.6 мянган төгрөг төгрөг нийт 2,806,799.6 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансаар хүлээн авч зарцуулсан байна.

Зам, тээврийн хөгжлийн яаманд улсын төсөвт үйл ажиллагаанаас төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө батлагдаагүй байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Зам, тээврийн хөгжлийн яам Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Зам, тээврийн хөгжлийн яамны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Зам, тээврийн хөгжлийн яамны 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Зам, тээврийн хөгжлийн яамны нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал:

1.1. Илрүүлэлт: Үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 17 нэр төрлийн 11,286.0 мянган төгрөгийн хөрөнгийг санхүүгийн програмд ашиглах жилийг буруу оруулж элэгдлийг буруу тооцоолсон байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

1.2. Эрсдэл: Энэ нь үнэн зөв батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль зөрчсөн байна.

1.3. Өгсөн зөвлөмж: Үндсэн хөрөнгөнд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулж, тооллогыг чанар, үр дүнтэй хийх, хөрөнгийн ашиглах жил болон элэгдлийг буруу тооцсон зөрчлийг давтан гаргахгүй байх

1.4. Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана

2. Бараа материалтай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт: материалын жилийн эцсийн тооллогын дүн санхүүгийн тайлангийн эцсийн үлдэгдлийн дүнгээс 4,381.4 мянган төгрөгөөр зөрүүтэй нь Нягтлан бодох

бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

2.2 Эрсдэл: Энэ нь үнэн зөв, эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна хяналт сул Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль зөрчсөн байна.

2.3 Өгсөн зөвлөмж: Бараа материалд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулж, тооллогыг чанар, үр дүнтэй хийх зөрчлийг давтан гаргахгүй байх

2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 6 дугаар сарын 30-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2,832,169,919.32</u>	<u>4,526,925,579.26</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	4,469,046,304.22
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	-	0.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	4,469,046,304.22
3121	Төгрөг	-	4,469,046,304.22
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	-	4,469,046,304.22
33	АВЛАГА	2,741,382,619.94	842,408.81
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	17,336,035.50	842,408.81
335	Бусад авлага	2,724,046,584.44	0.00
3351	Байгууллагаас авах авлага	2,724,046,584.44	0.00
35	БАРАА МАТЕРИАЛ	90,787,299.38	57,036,866.23
351	Түүхий эд материал	-	0.00
354	Хангамжийн материал	90,787,299.38	57,036,866.23
35410	Бичиг хэргийн материал	26,275,210.00	26,027,310.00
35420	Аж ахуйн материал	33,436,164.20	11,924,921.00
35430	Сэлбэг хэрэгсэл	3,702,000.00	0.00
35440	Түлш, шатах тослох материал	244,669.00	733,437.00
35470	Бусад хангамжийн материал	27,129,256.18	18,351,198.23
36	НӨӨЦИЙН БАРАА	-	0.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,635,280,633.25</u>	<u>2,596,624,172.03</u>
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	-	0.00
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,635,280,633.25	2,596,624,172.03
392	Биет хөрөнгө	1,634,703,966.55	1,768,435,505.33
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,554,001,079.70	1,549,894,744.40
39202	Хуримтлагдсан элэгдэл	(1,264,912,898.84)	(78,782,818.45)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	219,658,040.00	276,458,040.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(64,142,828.63)	(121,809,695.85)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	545,540,541.39	519,367,141.39
39206	Хуримтлагдсан элэгдэл	(470,090,402.33)	(466,585,611.12)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	352,916,525.09	350,788,102.23
39208	Хуримтлагдсан элэгдэл	(238,407,089.83)	(261,035,397.27)
39217	Ном	141,000.00	141,000.00
393	Биет бус хөрөнгө	576,666.70	828,188,666.70
39301	Програм хангамж	38,532,700.00	38,532,700.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(37,956,033.30)	(37,956,033.30)
39303	Бусад биет бус хөрөнгө	-	827,612,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-	0.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>4,467,450,552.57</u>	<u>7,123,549,751.29</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>14,284,000.00</u>	<u>4,226,727.35</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	14,284,000.00	4,226,727.35
413	Өглөг	14,284,000.00	4,226,727.35
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	4,226,727.35
4136	Бусад өглөг	14,284,000.00	0.00
41361	Байгууллагад төлөх өглөг	14,284,000.00	0.00

Зам, тээврийн хөгжлийн яамны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>4,453,166,552.57</u>	<u>7,119,323,023.94</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	4,453,166,552.57	7,119,323,023.94
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	5,871,077,340.11	6,698,689,340.11
51101	Өмч: - төрийн	5,871,077,340.11	6,698,689,340.11
51102	- хувийн	-	0.00
512	Хуримтлагдсан үр дүн	(1,417,910,787.54)	174,626,755.94
51210	Өмнөх үеийн үр дүн	1,424,506,413.57	(1,417,910,787.54)
51220	Тайлант үеийн үр дүн	(2,842,417,201.11)	1,592,537,543.48
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	-	246,006,927.89
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>4,467,450,552.57</u>	<u>7,123,549,751.29</u>

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	8,200,195,893.67	7,803,926,988.73
11	ТАТВАРЫН ОРЛОГО	-	-
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	398,726,901.20	1,775,844,761.73
120	Нийтлэг татварын бус орлого	398,726,901.20	1,775,844,761.73
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	398,726,901.20	1,775,836,761.73
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	1,604,325.48
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	398,726,901.20	1,751,985,769.25
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	22,246,667.00
120009	Бусад орлого	-	8,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	7,801,468,992.47	6,028,082,227.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,303,405,469.47	3,221,282,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,303,405,469.47	3,221,282,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,498,063,523.00	2,806,799,627.00
131103	ЗГНХ,ЗДНХерөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,498,063,523.00	2,806,799,627.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	10,521,704,399.04	6,211,389,445.25
21	УРСГАЛ ЗАРДАЛ	7,839,685,844.34	6,211,389,445.25
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,839,685,844.34	6,030,161,318.53
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,056,306,127.84	2,069,081,619.00
210101	Үндсэн цалин	1,318,354,265.94	2,069,081,619.00
210102	Нэмэгдэл	623,905,161.90	-
210103	Унаа хоолны хөнгөлөлт	114,046,700.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	225,584,614.59	248,257,072.74
210201	Тэтгэврийн даатгал	144,013,478.11	166,496,496.74
210202	Тэтгэмжийн даатгал	19,848,063.71	20,482,609.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	16,978,211.01	16,429,765.00
210204	Ажилгүйдлийн даатгал	4,067,714.52	4,077,109.00
210205	Эрүүл мэндийн даатгал	40,677,147.22	40,771,093.00
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	-	-
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	-
2104	Хангамж, бараа материалын зардал	80,452,649.60	111,715,896.84
210401	Бичиг хэрэг	32,995,764.00	31,063,808.00
210402	Тээвэр, шатахуун	13,926,080.00	10,333,472.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	14,723,690.60	18,233,220.69
210404	Ном, хэвлэл	-	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	18,807,115.00	20,780,360.12
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	-
210408	Бараа материал акталсны зардал	-	31,305,036.03
2105	Нормативт зардал	2,227,500.00	2,200,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	-
210502	Хоол, хүнс	-	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,227,500.00	2,200,000.00

Зам, тээврийн хөгжлийн яамны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,580,690.00	21,179,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	255,040.00	3,852,100.00
210604	Урсгал засвар	14,325,650.00	17,327,400.00
2107	Томилолт, зочны зардал	108,864,113.00	108,767,131.00
210701	Гадаад албан томилолт	-	-
210702	Дотоод албан томилолт	108,864,113.00	108,767,131.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	-	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,396,842,625.25	514,573,535.84
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,129,438,658.00	263,685,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	16,357,680.00	9,544,500.00
210803	Даатгалын үйлчилгээ	252,450.00	1,141,600.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	307,700.00	551,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	44,000.00	66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	27,800,662.25	25,465,735.84
210807	Газрын төлбөр	5,051,200.00	5,366,200.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	-	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	217,590,275.00	208,752,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	954,827,524.06	2,954,386,563.11
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	659,759,097.00	2,816,212,307.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	295,068,427.06	138,174,256.11
210904	Найдваргүй авлагын алдагдал	-	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,682,018,554.70	181,228,126.72
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	-
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	-
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	-	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	878,945,057.00	134,814,883.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	689,094,125.00	83,411,523.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	146,950,932.00	51,403,360.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	42,900,000.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,803,073,497.70	46,413,243.72
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,803,073,497.70	46,413,243.72
213304	Хөрөнгийн	-	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	-
2200	Дотоод эх үүсвэрээр	-	-
2260	Гадаад эх үүсвэрээр	-	-
226001	Гадаад эх үүсвэрээр	-	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(2,321,508,505.37)	1,592,537,543.48
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	520,908,695.74	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	503,853,895.04	-
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	17,054,800.70	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(520,908,695.74)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(2,842,417,201.11)	1,592,537,543.48

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	13,017,590,232.67	10,504,074,211.22
11	ТАТВАРЫН ОРЛОГО	00.00	00.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,184,355,809.67	4,475,991,984.22
120	Нийтлэг татварын бус орлого	5,184,355,809.67	4,475,991,984.22
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5,184,355,809.67	4,475,983,984.22
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	398,726,901.20	00.00
1200043	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих	4,785,628,908.47	2,723,998,214.97
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	00.00	1,751,985,769.25
120009	Бусад орлого	00.00	8,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	7,833,234,423.00	6,028,082,227.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,335,170,900.00	3,221,282,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,335,170,900.00	3,221,282,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,498,063,523.00	2,806,799,627.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,498,063,523.00	2,806,799,627.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	12,998,478,092.67	6,035,027,907.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	12,998,478,092.67	6,035,027,907.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,560,630,892.47	5,871,135,815.28
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,061,258,761.90	2,070,717,177.93
210101	Үндсэн цалин	1,323,306,900.00	1,289,563,077.93
210102	Нэмэгдэл	623,905,161.90	610,544,100.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	114,046,700.00	170,610,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	229,303,813.72	241,584,499.82
210201	Тэтгэврийн даатгал	229,303,813.72	241,584,499.82
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	00.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	76,465,529.60	81,465,263.69
210401	Бичиг хэрэг	29,685,764.00	35,766,108.00
210402	Тээвэр, шатахуун	13,846,080.00	10,822,240.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	14,723,690.60	18,233,220.69
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	18,209,995.00	16,643,695.00
2105	Нормативт зардал	2,227,500.00	2,200,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,227,500.00	2,200,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	25,402,922.00	26,282,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,207,472.00	8,954,700.00
210604	Урсгал засвар	21,195,450.00	17,327,400.00
2107	Томилолт, зочны зардал	108,864,113.00	108,767,131.00
210701	Гадаад албан томилолт	00.00	00.00
210702	Дотоод албан томилолт	108,864,113.00	108,767,131.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,397,349,155.25	523,907,335.84
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,129,438,658.00	263,685,600.00

Зам, тээврийн хөгжлийн яамны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	16,357,680.00	9,544,500.00
210803	Даатгалын үйлчилгээ	252,450.00	1,141,600.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	307,700.00	551,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	44,000.00	66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	27,800,662.25	25,465,735.84
210807	Газрын төлбөр	5,051,200.00	5,366,200.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	218,096,805.00	218,085,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	659,759,097.00	2,816,212,307.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	659,759,097.00	2,816,212,307.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	00.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,437,847,200.20	163,892,091.72
2132	Бусад урсгал шилжүүлэг	879,010,057.00	134,814,883.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	689,159,125.00	83,411,523.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	146,950,932.00	51,403,360.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	42,900,000.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	31,765,430.53	29,077,208.72
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	31,765,430.53	29,077,208.72
213304	Хөрөнгийн	00.00	00.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,527,071,712.67	
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,527,071,712.67	
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	19,112,140.00	4,469,046,304.22
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	19,112,140.00	00.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	19,112,140.00	00.00
2200	Дотоод эх үүсвэрээр	19,112,140.00	00.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	19,112,140.00	00.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-19,112,140.00	00.00
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
14	Бусад эх үүсвэр	00.00	00.00
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	00.00	00.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	4,469,046,304.22
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	4,469,046,304.22

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,871,077,340.11	-	1,408,651,694.43	7,279,729,034.54
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	15,854,719.14	15,854,719.14
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,871,077,340.11	-	1,424,506,413.57	7,295,583,753.68
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(2,842,417,201.11)	(2,842,417,201.11)
D01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,871,077,340.11	-	(1,417,910,787.54)	4,453,166,552.57
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,871,077,340.11	-	(1,417,910,787.54)	4,453,166,552.57
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	246,006,927.89	-	246,006,927.89
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	827,612,000.00	-	1,592,537,543.48	2,420,149,543.48
D09	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,698,689,340.11	246,006,927.89	174,626,755.94	7,119,323,023.94

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ төгрөгөөр /

Код	Эдийн засгийн ангиалал	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,221,282,600.00	3,192,213,391.28	29,069,208.72	99.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,221,282,600.00	3,192,213,391.28	29,069,208.72	99.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,060,872,800.00	3,057,398,508.28	3,474,291.72	99.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,070,837,500.00	2,070,717,177.93	120,322.07	100.0
210101	Үндсэн цалин	1,289,683,400.00	1,289,563,077.93	120,322.07	100.0
210102	Нэмэгдэл	610,544,100.00	610,544,100.00	-	100.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	170,610,000.00	170,610,000.00	-	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	241,584,500.00	241,584,499.82	0.18	100.0
210201	Тэтгэврийн даатгал	161,056,400.00	161,056,399.82	0.18	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	20,132,000.00	20,132,000.00	-	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	16,105,600.00	16,105,600.00	-	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	4,026,400.00	4,026,400.00	-	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	40,264,100.00	40,264,100.00	-	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	81,466,400.00	81,465,263.69	1,136.31	100.0
210401	Бичиг хэрэг	36,455,000.00	35,766,108.00	688,892.00	98.1
210402	Тээвэр, шатахуун	17,220,700.00	10,822,240.00	6,398,460.00	62.8
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	15,139,200.00	18,233,220.69	(3,094,020.69)	120.4
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	12,651,500.00	16,643,695.00	(3,992,195.00)	131.6
2105	Нормативт зардал	2,227,500.00	2,200,000.00	27,500.00	98.8
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,227,500.00	2,200,000.00	27,500.00	98.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	26,284,400.00	26,282,100.00	2,300.00	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,207,500.00	8,954,700.00	(4,747,200.00)	212.8
210604	Урсгал засвар	22,076,900.00	17,327,400.00	4,749,500.00	78.5
2107	Томилолт, зочны зардал	108,867,800.00	108,767,131.00	100,669.00	99.9
210702	Дотоод албан томилолт	108,867,800.00	108,767,131.00	100,669.00	99.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	527,129,700.00	523,907,335.84	3,222,364.16	99.4
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	264,437,100.00	263,685,600.00	751,500.00	99.7
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	9,800,000.00	9,544,500.00	255,500.00	97.4
210803	Даатгалын үйлчилгээ	2,812,900.00	1,141,600.00	1,671,300.00	40.6
210804	Тээврийн хэрэгслийн татвар	574,000.00	551,800.00	22,200.00	96.1
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	75,200.00	66,000.00	9,200.00	87.8
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	25,888,500.00	25,465,735.84	422,764.16	98.4
210807	Газрын төлбөр	5,445,000.00	5,366,200.00	78,800.00	98.6
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	218,097,000.00	218,085,900.00	11,100.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,475,000.00	2,475,000.00	-	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,475,000.00	2,475,000.00	-	100.0

Зам, тээврийн хөгжлийн яамны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	160,409,800.00	134,814,883.00	25,594,917.00	84.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	72,909,100.00	51,403,360.00	21,505,740.00	70.5
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	87,500,700.00	83,411,523.00	4,089,177.00	95.3
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,221,282,600.00	3,192,213,391.28	29,069,208.72	99.1
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,221,282,600.00	3,192,213,391.28	29,069,208.72	99.1
310001	Улсын төсвөөс санхүүжих	3,221,282,600.00	3,192,213,391.28	29,069,208.72	99.1

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	2019.02.25	Аудитын нэр:	2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан	Аудитын код:	
Шалгагдсан байгууллагын нэр:	Зам, тээврийн хөгжлийн яам			Мянган төгрөгөөр	
				САГ-2019/287/СТА-ТШЗ	

Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллаг аас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
		Нэр	Албан тушаал	Овог нэр
1	2	3	4	5
Үндсэн хөрөнгөнд 17 нэр төрлийн 11,286 мянган төгрөгийн хөрөнгийг санхүүгийн програмд ашиглах жилийг буруу оруулж элэгдлийг буруу тооцоолсон байна.	11,286.0	Зөвлөмж	Хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн хэлтсийн дарга, Нягтлан бодогч	Ч.Ренчиндамба Г.Түвшинзаяа
Бараа материалын жилийн эцсийн тооллогын дүн санхүүгийн тайлангийн эцсийн үлдэгдлийн дүнгээс 4,381.4 мянган төгрөгөөр зөрүүтэй байна.	4,381.4	Зөвлөмж		
Зөвлөмжийн дүн	15,667.4			

